



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль,
Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль

Хөтөлбөрийн нэр: Нийгмийн ажил /Эрүүл мэндийн/

Индекс: 092301

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Байгалмаа

Гишүүд: Н.Нямдорж

Л.Алтангэрэл

Он сар өдөр: 2019/04/18

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- АШУҮИС – Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
- АНУ – Америкийн Нэгдсэн Улс
- БМИҮЗ – Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- НЭМС – Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
- ЭМНА – Эрүүл Мэндийн Нийгмийн Ажил

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль Mongolian National University of Medical Sciences, School of Public health	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нийгмийн ажил /Эрүүл мэндийн/ Social work /Health/	
Индекс	092301	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Ч.Байгалмаа – МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн ахлах багш 2. Н.Нямдорж – ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн нийгмийн ажлын ахлах багш 3. Л.Алтангэрэл – Монголын Аутизмын Холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал 	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	1. Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019-04-09 Мягмар гараг	Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах: Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойшх мэдээллийг оруулах/
	2019-04-09	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана
	2019-04-09	Сургуультай танилцах
	2019-04-09	Оюутнуудтай хийх уулзалт
	2019-04-09	Багш нартай хийх уулзалт
	2019-04-09	Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана
	2019-04-09	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах
	2019-04-10 Лхагва гараг	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	2019-04-10	Ажил олгогчидтой хийх уулзалт
	2019-04-10	Төгсөгчидтэй хийх уулзалт
	2019-04-10	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	2019-04-10	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах Шинжээчдийн багийн уулзалт
	2019-04-10	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ
Шалгуур шаардлага /журам/	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн зорилго

Нийгмийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх түвшинд үйлчлүүлэгч хүн амын нийгэм-сэтгэл зүйн асуудал, хэрэгцээг үнэлэх тэдний нөөц боломжийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх

Хөтөлбөрийн зорилт

- Хүн амын эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн сайн сайханд нөлөөлөх хүчин зүйлсийг танин мэдэх
- Хүний эрх, шударга ёсыг дээдэлж, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх нийгмийн ажлын үнэт зүйл, мэргэжлийн ёс зүйн зарчимд суралцах
- Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээний бүх хүрээнд нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг хүргэхэд шаардагдах үзэл баримтлал, онол, арга зүйг эзэмших
- Хүн амын ялгаатай бүлэг, олон нийтийг чадваржуулах, тэдэнд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээг хүргэх арга зүйг эзэмших
- Олон мэргэжлийн багтай үр дүнтэй хамтран ажиллах, манлайлах, зохион байгуулах мэдлэг, чадварыг эзэмших
- Нийгмийн болон эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээг боловсронгуй болгоход нөлөөлөх үйл явцыг тодорхойлох, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах мэдлэг, чадвар эзэмших
- Нийгмийн асуудлыг танин мэдэх, илрүүлэх, дүн шинжилгээ хийх чадварт суралцах

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Хичээлийн төрөл	Заавал судлах хичээлийн	Сонгон судлах хичээлийн	Нийт судлах хичээлийн	
	кр	кр	кр	%
Ерөнхий суурь	28	4	32	24
Мэргэжлийн суурь хичээл	28	2	30	23
Мэргэшүүлэх хичээл	54	2	56	42.4
Дадлага			14	10.6
Нийт дүн	124 (93.9%)	8 (6.1%)	132	100.0

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо төгсөгчид болон ажил олгогчийн хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгааг 3 жилд тутамд хийж, эрүүл мэнд болон нийгмийн ажлын салбарын хөгжлийн төлөв байдал, бодлогын чиглэлийг судлан, нийгмийн болон оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд өөрийн үнэлгээ хийсэн байна.
- Хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, эрүүл мэндийн нийгмийн ажлын төгсөгчдийн холбоотой хамтран нийгмийн ажлын хэлэлцүүлэг, хурал, уулзалт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Мөн нийгмийн ажилтан бэлтгэхэд голлох үүрэг гүйцэтгэж буй үндэсний 4 их дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна. Үүний зэрэгцээ нийгмийн ажлын мэргэжлийн үндэсний стандарт (MNS 5323-95:2009), олон улсын стандарттай харьцуулалт хийж, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АНУ-ын Нийгмийн ажлын боловсролын зөвлөлөөс гаргасан Нийгмийн ажлын бакалавр, магистрийн хөтөлбөрийн стандарт ба боловсролын бодлогын баримт бичиг (2015), Олон улсын түвшинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нийгмийн ажлын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад мөрдөх зарчим (2001), АНУ-ын Колумбын их сургууль, Нью-Йоркийн их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан өөрчлөлт шинэчлэлтийг 2 шинжлэх ухааны уулзварт амжилттай хийжээ.
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны агуулгыг нийгмийн ажлын агуулгатай уялдуулан мэргэжилтний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг цогц чадамж байдлаар тодорхойлон чанартай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарч ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо ажил олгогч, төгсөгчдийн хүрээнд төдийгүй үйлчлүүлэгч иргэд, олон нийтийн хэрэгцээг судлах

Зөвлөмж:

-

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгоо байгууллагынхаа эрхэм зорилго, нийгмийн ажлын мэргэжлийн үндэсний болон олон улсын стандарттай уялдуулан боловсруулсан нь давуу талтай юм.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтын биелэлтийг оролцогч талуудын судалгаанд тулгуурлан тодорхойлдог нь сайшаалтай байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, цогц чадамж зэргийг “Нийгмийн ажил. Бакалаврын хөтөлбөр Боть I” –т тодорхойлж тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тэдний эзэмшвэл зохих цогц чадамж байдлаар тодорхойлж, ази тивийн болон олон улсын жишигт нийцүүлэн “ЭМНА мэргэжилтний цогц чадамж” бичиг баримтыг боловсруулж, сургуулийн захирлын зөвлөл, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, баталгаажуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго тодорхойлох болон хөтөлбөрт оруулсан өөрчлөлтийн талаар холбогдох олон нийтэд мэдээлэх тал дээр анхаарах

Зөвлөмж:

-

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд нь тухайн хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагатай холбоотой агуулга, сургалтын арга зүй, үнэлгээний талаар тусгасан байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг судалгааны үр дүн, бодлогын бичиг баримттай холбогдуулан шинэчлэн сайжруулсан нь сайшаалтай байна.
- Хичээлийн хөтөлбөрийг тэнхим, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн зохих шатлалаар баталгаажуулж байгаа нь хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээ, хоорондын уялдаа холбоо, эрэлт хэрэгцээнд нийцсэн эсэхийг баталгаажуулах боломжийг бүрдүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид болон ажил олгогчдоос хэрэгцээг тодорхойлох судалгаа авах, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах зэргээр тэдний санал зөвлөмжийг тусган хөтөлбөрөө сайжруулсаар ирсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн өөрчлөлт тус бүрийн /3 удаагийн өөрчлөлт/ үндэслэлийг агуулга, арга зүй, үнэлгээний буюу чанарын талаас нь тодорхой баримтжуулахад анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахдаа агуулга талаас нь олон эх сурвалжид тулгуурлан сайтар авсан үзсэн байгаа ч цаашид арга зүйн болон үнэлгээний хувьд өөрчлөлтийг хэрхэн хийх талаар судалж, дүн шинжилгээ хийх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээл тус бүрийн хөтөлбөрийг нэгдсэн байдлаар хэвлэж гаргасан нь давуу тал болсон байна. Энэ нь багш, суралцагч нар болон оролцогч талууд ЭМНА-ын сургалтын хөтөлбөртэй танилцах, хичээлийн нэр, залгамж холбоо, агуулгын товчийг харах боломжтой байна.
- Дадлага хичээлийн агуулга, цагийн багтаамж нь ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хөтөлбөртэй харьцуулахад их байна. АШУҮИС-ийн ЭМНА-ын сургалтын хөтөлбөрт дадлагын цаг нь 468 цаг. Олон улсын стандартад дадлагын цаг нь 400-600 цаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага

- АШУҮИС-ийн нэг салбар сургуулийн хувьд өвчтөн болон түүний гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг боловсруулах боломж бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Дадлагын чиглэлээр хамтран ажиллах гэрээний тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Зайн болон цахим хичээлүүдийг E-контентийн түвшинд боловсруулж сургалтад ашигладаг. Сургалтын хөтөлбөрт орсон бүх сонгон суралцах хичээлүүд болон дээд боловсролын суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлүүдийн шалгалтыг цахим хэлбэрээр авч байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Үр дүнд суурилсан сургалт явуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Төгсөлтийн дараах сургалтыг хөгжүүлэх бүрэн боломж бүрдсэн байна. Үүнийг цаашид ашиглах шаардлагатай.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Эрүүл мэндийн нийгмийн ажил” сургалтын хөтөлбөрөөр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлж байна. Сургалтын хөтөлбөрт орсон бүх сонгон суралцах хичээлүүд болон дээд боловсролын суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлүүдийн шалгалтыг цахим хэлбэрээр авч байна.
- Сургалтын хөтөлбөр дэх хичээл хоорондын залгамж холбоог зохих хэмжээнд хангаж, оролцогч талуудын /багш, суралцагч, төгсөгч, ажил олгогч/ саналыг авч сайжруулалт хийж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- ЭМЯ-нд Эрүүл мэндийн нийгмийн ажил, үйлчилгээ хариуцсан нэгжийг байгуулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Боломжит хэмжээнд орчин нөхцөлийг зохион байгуулалт хийж, эрүүл аюулгүй орчны шаардлагыг хангахуйц ханын будаг, материал, хүний биед хоргүй будаг эмульс зэргийг ашиглан дотоод засал хийсэн байгаа нь давуу талтай байна.
- Анги танхим болон лаборатори зэрэг нь ашиглалтын хувьд зохион байгуулалт сайтай байхаар тооцож хийгдсэн байна.
- Цахим орчин, бие даан ажиллах орчныг хангаж шаардлагатай хэмжээнд хангасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгааны арга зүйн төв үйл ажиллагаа явуулж, ахисан түвшний суралцагчдад шаардлагатай программ хангамж, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгч байгаа нь онцлог байна.
- Онлайн хурал хийх боломжтой өндөр хурдны интернэт орчин бүхий тоноглогдсон нөхцөл бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Тус сургууль дээр хөндлөнгийн шинжээчээр ажиллах үед багш нарын өрөө тасалгаа ажиллах орчны хувьд анхаарах шаардлагатай нь харагдсан. Гэвч тус сургуулийн байрны зарим давхарт байрлах бусад нэгж, салбар сургууль зэрэг нь шинээр ашиглалтад орж буй АШУҮИС-ийн Сургалтын эмнэлэг рүү нүүн шилжиж байгаа тул өрөө тасалгаа сулрах талаар мэдээлж байлаа. Эдгээр өрөөг тохижуулж сайжруулан ашиглавал багш нарын болон суралцагчдын ажиллах, суралцах, бие даан үйл ажиллагаа эрхлэх орчин нөхцөл харьцангуй сайжрах боломжтой, тус асуудал тодорхой хугацааны дараа шийдэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.
- Шинээр нээгдэж буй танхимын ашиглалт, зохион байгуулалтыг хангаж чадвал бүрэн дүүрэн ажиллахад дөхөмтэй.

Зөвлөмж:

-

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Цахим хичээл бэлтгэх мултистуди болон номын сан зэрэг нь тогтвортой үйл ажиллагаатай, судалгааны программ хангамж, хичээл тус бүрээр бэлтгэгдсэн бөгөөд онлайн хичээлийн ашиглалт хангалттай сайн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- Сургалт, судалгаа хийх зориулалт бүхий техник хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангах хэрэгцээ шаардлага байлаа.

Зөвлөмж:

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Төрийн болон ТББ-тай хамтран ажиллах, гэрээ байгуулах зэргээр өөрсдийн боломж бололцоо, хамрах хүрээнд хийх боломжгүй гарын авлага, хэрэглэгдхүүн зэрэг шаардлагатай материаллаг нөөцийг бүрдүүлэхэд анхаарах. Жишээлбэл: Монголын Дауны Холбоо, Монголын Аутизмын Холбоо зэрэг энэ чиглэлээр тодорхой хэмжээнд үйл ажиллагаа явуулж, харьцангуй мэргэшсэн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл цөөнгүй байдаг.
- Төгсөгчдөөс санал асуулга авч, суралцагчдын эзэмшвэл зохих практикт түгээмэл хэрэглэгдэх ур чадварын талаар сургалтын болон бусад үйл ажиллагаанд тусгавал үр дүнтэй. Жишээлбэл: Зөв зохистой харилцаа, ярианы зөв дадал гэх мэт.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өндөр хурдны интернэт орчинд мэдээллийг түргэн шуурхай авах боломж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай ерөнхий суурь хичээлийн болон анагаах, нийгмийн эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээрх гарын авлага, сургууль болон багшийн судалгаа, тайлангийн эмхэтгэл, ашиглагдаж буй ном хэрэгсэл оюутанд хүртээмжтэй хангалттай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС нь өөрийн гэсэн том номын сантай ба цэвэрхэн тохилог орчинд бие даан ажиллах, суралцах орчин нөхцөл хангагдсан байна.

Анхаарах асуудал:

- Нийгмийн ажлын чиглэлээрх мэргэжлийн үндсэн сурах бичгийн төрөл, тоо хэмжээ харьцангуй байна. Тус салбар нь өөрөө шинэ, нийгэм цаг үеэ дагаж урсгал, чиг хандлага өөрчлөгддөг хэдий ч тухайн цаг үе, нөхцөл байдлаа мэдэрсэн өөрийн гэсэн сурах бичиг байх хэрэгцээ шаардлага өндөр гэж үзэж байна.
- Эх сурвалжийн хайлт хийх нэгдсэн нэг систем, зохион байгуулалтын ажлын хэрэгцээ байна. Төрөлжсөн байдлаар ном сурах бичгийн ангилал байгаа хэдий ч

түлхүүр үгээр хайх боломжтой болгох, гадаад эх сурвалжаас бэлтгэсэн сургалтын хэрэглэгдхүүн зэргийг төрөл, агуулга, ангилал, бусад зүйлсээс нь хамаарч гарын авлага, сурах бичгийн түвшинд боловсруулж номын баяжилт хийхэд анхаарах.

Зөвлөмж:

-

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хөтөлбөрийн зөвлөл, хөтөлбөрийн дэд зөвлөл, захирлын зөвлөл, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулахын зэрэгцээ хичээлийн хөтөлбөрийг тус үе шатаар хэлэлцүүлдэг нь сургалтын чанарт зэрэгээр нөлөөлөх давуу талтай юм.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээл тус бүрээр сэтгэл ханамжийн судалгаа авч, төгсөгч, ажил олгогчдоос гарсан санал, хүсэлтийн дагуу сургалтын чанарыг сайжруулахын тулд тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлсэн нь сайшаалтай байна.
- Суралцагчийг үнэлэх журам, сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам, багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмуудыг ашиглахын зэрэгцээ дотоод хяналтын арга зүйч тодорхой хуваарийн дагуу хяналт хийх тогтолцоог бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Эрх зүйн баримт бичиг буюу журмуудын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний талаарх мэдээлэл хангалттай бус байгааг анхаарах

Зөвлөмж:

- Тэнхимийн хөгжлийн хөтөлбөрийн богино, дунд хугацааны стратеги төлөвлөлт, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, санал зөвлөмжийг баримтжуулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, сургалтын хөтөлбөр сайжруулах, боловсруулах, судалгаа эрдэм шинжилгээ, нийгэм олон нийтэд зориулсан мэргэжлийн үйл ажиллагаа зэрэг чиглэлүүдээр төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Суралцагчид болон багш нарыг хөгжүүлэх, чадавхжуулахад чиглэсэн олон талын хамтын ажиллагаа бүрдүүлж ажилласан давуу тал харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- ТББ болон төрийн байгууллагатай хамтран ажиллахын зэрэгцээ нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд байгууллага, олон нийтэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх, төсөл хэрэгжүүлж туршлага, үр дүнг оюутны сургалтад ашиглаж, хөгжүүлж буй байдал ажиглагдсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын дийлэнх нь гадаадын их дээд сургуульд багшийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдан, тухайн сургуулийн багш нартай хамтран хөтөлбөрөө сайжруулах, судалгаа шинжилгээний ажил хийх, сургалт зохион байгуулах зэргээр хамтран ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, нийгэмд чиглэсэн үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн тоо, гарсан үр дүн, дүгнэлтийн талаар тодорхой тусгах. Тухайлбал, сургалтад хамрагдсан хүний тоо, ямар үр дүн гарсан гэх зэрэг.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжүүлсэн төсөлд оролцсон багш нарын тоон мэдээлэл, бүртгэл судалгааг системтэй бүрдүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС нь хөгжлийн бодлого (2015 - 2024)-доо санхүүжилт хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрт тогтолцоог бий болгох, захиран зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар тусгасан бөгөөд түүний дагуу НЭМС санхүүгийн хувьд харьцангуй бие даах бодлогыг хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллаж байгаа нь давуу талтай. Үндсэн үйл ажиллагаанаас гадна үндсэн бус үйл ажиллагаа болох төсөл, хөтөлбөр, лабораторийн үйл ажиллагаанаас санхүүжилтийн тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлал, 2018 онд 110,000,000 төгрөг хүртэлх орлогыг тус үйл ажиллагаанаас олсон байна.
- Хөтөлбөрийн нийт санхүүжилтээс багш, суралцагчийн хөгжилд зарцуулж буй зардлыг 2014 оноос 2018 онд 4 хувиас 20 хувь хүртэл өсгөж чадсан байна.

Анхаарах асуудал:

- Төрийн болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг, төслийн санхүүгийн зарцуулалтад хийсэн дүн шинжилгээг тусгах нь зүйтэй

Зөвлөмж:

- Хэдийгээр багш, суралцагчийн хөгжилд зарцуулж буй зардал жил ирэх тутамд өссөн үзүүлэлттэй байгаа ч эрдэм шинжилгээний зардлыг одоогийн түвшнөөс нэмэгдүүлэх боломжийг судлах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Мэргэжлийн гишүүнчлэл бүхий хаалттай цахим сүлжээ буюу фейсбүүк хуудас, төгсөгчдийн чуулга уулзалт, онол практикийн бага хурал, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” нээлттэй лекц, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Эрүүл мэндийн нийгмийн ажлын чиглэлээр суралцсан төгсөгчдийнхөө дунд чуулга уулзалт зохион байгуулж, ЭМНА-ын практикт тулгамдаж буй асуудлууд, Эрүүл мэндийн нийгмийн ажилтан бэлтгэх сургалтыг сайжруулах, мэргэжлийн олон нийтийн цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэргийн талаар хэлэлцэж, сургуулийн удирдлагуудад санал хүсэлтийг хүргүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа урьдчилан боловсруусан хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд хэрэгжсэн эсэхийг анхаарах

Зөвлөмж:

- Цаашид хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд ил тод түгээх талаар нэлээд тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. АШУҮИС болон НЭМС-ийн цахим хуудас, хаяг, олон нийтийн сүлжээ, сэтгүүл, товхимол, тараах материал ашиглан мэдээллийг ил тод түгээж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн талаарх баримт мэдээллийг ил тод мэдээлдэг. Хичээл бүрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө, үнэлгээний аргачлалын талаарх мэдээллийг цахим орчинд /www.teacher-web.xcloud.mn/ байршуулдаг.

Анхаарах асуудал:

- Мэдээллийг хэрхэн шинэчилдэг, цахим мэдээллийн тогтмол ажиллагаа хэрхэн хангагдаж байгаа талаар анхаарах

Зөвлөмж:

-

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Танилцах хичээл эхний 7 хоногт ордог. Хичээлийн сэдэв болон багш нарын мэдээлэл зэргийн нэгдсэн төлөвлөгөөтэй.
- Суралцагчдад зориулсан мэдээлэл гарын авлага, тараах материал зэргийн түгээлт элсэгчдэд зориулсан мэдээлэл бүхий үйл ажиллагаа, зохистой байдал.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Танилцах хичээл нь шинэ элсэгчдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, элсэн орсон хөтөлбөрийн агуулга, зорилгыг ойлгомжтой болгоход үр өгөөжтэй байна.

Анхаарах асуудал:

- Суралцагч элсүүлэх хяналтын тоо бага байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад хангалтгүй байна. Сургуулийн зүгээс холбогдох төрийн байгууллага руу хандаж хяналтын тоог нэмэгдүүлэх тал дээр санал хүсэлтээ илэрхийлэх

- Элсэлтийн босго онооны тухайд дахин судалж үзэх хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг анхаарах

Зөвлөмж:

-

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Судалгааны арга зүйн төвийг байгуулж, шаардлагатай техник хэрэгсэл, программ хангамжийг бүрдүүлсэн байна. Энэхүү төвийн үйл ажиллагаа 2 сургалтын танхимд байрлах тул хэрэгцээ шаардлага хангаж, хүрэлцээ боломжийг шийдвэрлэж чаджээ.
- Сургалтын алба, оюутны алба нь өөр өөрийн хариуцсан чиглэлээр сургалт, дэмжлэг, арга зүйн зөвлөгөөг үзүүлж, шаардлагатай нөхцөлд хариуцсан багш мэргэжилтэн зөвлөгөө өгөх, гадны бусад нөөц дэмжлэг хэрэгцээтэй нөхцөлд дэмжин зуучлах зэргээр холбох ажлыг хийж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн нь нөхцөл байдлыг тодорхой болгох, хөтөлбөрийг сайжруулахад тодорхой хэмжээнд үнэлэлт дүгнэлт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг баяжуулах, тогтмолжуулах тал дээр илүү анхаарах.
- Бусад салбар чиглэлийн байгууллагатай Хамтран ажиллах тал дээр илүү анхаарах

Зөвлөмж:

- Хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүй, хөгжлийн бэрхшээлийн талаарх бусад байгууллага, иргэний нийгэм зэрэг газруудтай илүү хамтран ажиллах.
- Суралцагчдад оюутны амьдралд дасах, хөлөө олоход нь туслах зорилгоор ахлах ангийн суралцагчдын “tutor” тогтолцоог судалж үзэх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны холбооны үйл ажиллагаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв үйл ажиллагаа явуулж байна.
- Сургалтын тэтгэлэг хөнгөлөлт урамшууллыг явуулж, тодорхой шалгуур хангасан суралцагч хамрагдах боломжийг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Сайн дурын үйл ажиллагааг үнэлэх, нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Суралцагч нь хөтөлбөрийн мөн чанар, цаашлаад энэ чиглэлийн чадварлаг хүний нөөц болох үүднээс Сайн дурын үйл ажиллагааг дэмжих, нэмэгдүүлэх, баяжуулах хэрэгцээ шаардлага өндөр гэж үзэж байна. Сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулж олон зүйлийг сурч мэддэг гэсэн олон улсын жишиг, шалгуурыг тооцон үзэж, энэ чиглэл рүү хүчтэй орох нь зохистой. Сургалтын агуулгад харааны болон дохионы хэлний бэрхшээлтэй хүнтэй харилцах дадлага хичээл орох нь сайшаалтай хэдий ч хөгжлийн сүүдэрт үлдэх гээд байдаг оюуны бэрхшээлтэй зэрэг нийгмийн ялгаварлан гадуурхалтад өртөх магадлалтай бүлгийн талаар ойлголт мэдээлэлтэй байх, тэдгээр хүмүүстэй харилцаж чаддаг болох, мөн байгаль орчны бохирдол, нийгмийн стресс зэрэг нийгмийн эрүүл мэнд, бусад түгээмэл хөндөгддөг асуудалтай холбоотой үйл ажиллагаанд сайн дураар оролцох идэвхийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Энэ чиглэлийн үйл ажиллагаанд оролцож буй суралцагчийг дэмжих талаар хөтөлбөр, журам, зохицуулалтын бусад баримт бичгийг гаргах боломжийг судлах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч олон хүчин зүйлийн нөлөөгөөр шилжилт хөдөлгөөн хийдэг ба түүнийг тодорхой хэмжээнд чирэгдэлгүй байхаар зохицуулалт хийгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Элсэн орсон суралцагчийг завсардуулахгүй байх талын арга хэмжээг боломжит хэмжээнд авах

Зөвлөмж:

- Төлбөрийн хувьд бэрхшээлтэй байгаа суралцагчийн тухайд оюутны сангийн зээл, бусад эх үүсвэрийн талаар мэдээлэл өгөх, шалгуур шаардлагыг хангавал сургууль батлан даах хэлбэрээр завсардахгүй байх тал дээр анхаарч үзэх.
- Суралцагчдад дээд боловсролын үнэ цэнийг ойлгуулахын зэрэгцээ гэр бүл төлөвлөлт, ирээдүйн зорилгоо тодорхойлоход дэмжлэг үзүүлэхүйц уулзалт, сургалт, яриа хэлэлцүүлгийг тогтмол хийж байх

- Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлж, суралцагчийг идэвхжүүлэх тал дээр төсөл, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах
- Элсэн суралцагчдад эхний үед оюутны амьдралд дасах, хөлөө олоход нь туслах зорилгоор “tutor” тогтолцоог судалж үзэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн дагуу сургалтын багцаа хангаж, төгсөлтийн шалгалтаа хангасан суралцагч диплом, энгэрийн тэмдэг авч байна.
- Төгсөгчийн талаарх мэдээллийг авч болох цахим программын сайжруулалт хийгдэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Төгсөгчийн талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт мэдээлэл авч болох лавлагааны хэсэг байвал Ажил олгогч мэдээлэл авах тохиолдолд үнэн зөв, шуурхай мэдээллээр хангагдах боломжтойг анхаарах

Зөвлөмж:

- Одоо суралцаж буй суралцагчаас дипломоос гадна “мэргэжлийн” гэдгийг ялгаж өгөх мэргэжлийн зэрэг олгодог байвал гэсэн хүсэлт гарсан ба энэ талаар судалж үзэх. Үнэхээр тийм хэрэгцээ шаардлага байгаа эсэх талаар тандалт хийх

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- “Эрүүл мэндийн нийгмийн ажил” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавх бүрдсэн байна. Нийт багшлах болон хүчний 35,7% нь эрдмийн зэрэг цолтой байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багшлах боловсон хүчнийг АНУ, Израйль, Итали, Япон улсуудын ижил төрлийн сургуулиудад Эрүүл мэндийн нийгмийн ажлын боловсролын чиглэлээр урт болон богино хугацаагаар мэргэшүүлж сургасан байна.

Анхаарах асуудал:

•

Зөвлөмж:

•

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- “Багш хөгжлийн төв” байгуулж, эрдэм шинжилгээ, судалгаа, сурган хүмүүжүүлэх, хувь хүний хөгжил, урлаг спортын сургалт, семинаруудыг зохион байгуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Багшийг хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж үр дүнг тооцох

Зөвлөмж:

- Багшийн зэрэглэлийг дээшлүүлснээр багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын бүтээмж дээшлэх боломжтой.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ЭМНА-ын багш нар 2014-2019 оны хичээлийн жилд төсөл-18, ЭШ-ний хурал-14, өгүүлэл-102, илтгэл-183, сурах бичиг-8, гарын авлага-18 оролцож, хийж, бүтээж, хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хичээлийн жилд хамрагдсан сургалт семинарын тоо 1:9,5 байна.

Анхаарах асуудал:

- Нийгмийн ажлын боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоог нэмэгдүүлэх
- Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хөтөлбөр бүрээр гаргаж, харьцуулалт хийх

Зөвлөмж:

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш бүр хичээлийн жилд өөрийн үнэлгээний тайлан хийж, багшийн оноогоор үнэлдэг байна. Багш нараа сургалтад хамруулан, эрдэм шинжилгээ, заах арга барилыг нэмэгдүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Багшийн ажиллах орчин, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах

Зөвлөмж:

- Багш нарын урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмыг бүрдүүлэн, чанарын баталгаажилтын алба ажилладаг нь сайшаалтай байна.
- Түүнчлэн хөтөлбөрийн зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж дотооддоо чанарыг хангах, баталгаажуулах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгааг давуу тал гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС-ийн хүрээнд чанарын баталгаажилтын алба ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөр, хэрэгжилт, түүнд хийсэн үнэлгээний талаарх мэдээллийг тодорхой баримтжуулахад анхаарах

Зөвлөмж:

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үр дүнтэй байдал, хэрэгжилт, сайжруулах асуудлын талаар хэд хэдэн судалгаа тандалт хийсэн байна. Ажил олгогчийн судалгаа, төгсөгчдөөс авсан судалгаа зэрэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчоос судалгаа авсан нь зохистой байлаа

Анхаарах асуудал:

- Зах зээл дээрх энэхүү чиглэлийн ажлын байрны тоо их байгаа талаар дурдаж байгаа ч энэхүү хэрэгцээ шаардлагыг хангах хүний нөөцийг бэлтгэн гаргах квот нь хангалтгүй байгаа тул энэ талаар дахин судалж, мэргэжлийн эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлэх, уламжлах

Зөвлөмж:

- Эрүүл мэндийн салбарын Ажил олгогчоос гадна өөр бусад салбар чиглэлээр энэхүү ажлын байрны хэрэгцээ шаардлага байгаа эсэх, тэдэнд хэрэгцээтэй бол ямар чиглэлийн хүний нөөц хэрэгцээтэй байгаа талаар санал авах, судалгаа хийх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Эрүүл мэндийн нийгмийн ажилтан” бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэ нь оролцогч талуудын төлөөлөл болох ажил олгогч, төгсөгчдийн санал болон сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Олон улсын хэмжээнд хөтөлбөрийн хамтран ажиллах хүрээг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах

Зөвлөмж:

-

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан


ДҮГНЭЛТ

Нийгмийн ажил /Эрүүл мэндийн/ хөтөлбөр нь Монголын нийгмийн ажлын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн сургалтын хөтөлбөр болсон байна. Хөтөлбөрийг нийгмийн эрэлт хэрэгцээ, улс орны бодлого, олон улсын чиг хандлагатай нийцүүлэн шинэчлэн сайжруулсаар ирсэн бөгөөд тус хөтөлбөрөөр суралцагчид нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой нь тодорхой харагдаж байна.


Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн “Нийгмийн ажил /Эрүүл мэндийн/” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг 

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг 

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг 

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Оюутны дадлагын баазыг өргөжүүлэх. Тус хөтөлбөрөөр суралцагч нь одоогийн байдлаар эрүүл мэндийн салбарын янз бүрийн шатлалын байгууллагад ихэвчлэн дадлага хийж байна. Тэдний эзэмшиж буй мэргэжил болох нийгмийн ажлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, дадлагын байгууллагуудыг өргөжүүлснээр суралцагчдын практик чадвар, хандлагыг улам хөгжүүлэх боломжтой.
2. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлагыг нөөцийг бүрдүүлэн ажиллаж байгаа ч нийгмийн ажлын мэргэшүүлэх хичээл тус бүрийн үндсэн сурах бичгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.
3. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны эрэлт хэрэгцээ их байгаа учраас тус мэргэжлээр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг судалж, бодит арга хэмжээ авах нь тухайн салбарт ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэхэд чухал болохыг анхаарах шаардлагатай.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албантушаал	Зэрэгцол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ц.Нямсүрэн	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Тэнхимийн эрхлэгч	15 жил	Сэтгэлгээний түүх, соёл Философийн үндэс Ёс зүйн үндэс
2	Х.Дамдинжав	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Профессор	52 жил	Анагаах ухааны ёс зүй, Био-анагаахын ёс зүй
3	М.Сугармаа	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Дэд профессор	14 жил	Эмнэлгийн нийгмийн ажил, Геронтологи, гериатрын үндэс, Дадлагын менежмент, Судалгааны ажлын ёс зүй
4	Б.Буяндэлгэр	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Ахлах багш	13 жил	Монголын түүх, соёл, ёс заншил Сэтгэлгээний түүх, соёл, Соёл судлалын үндэс Философийн үндэс
5	С.Хандмаа	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Ахлах багш	12 жил	Нийгмийн ажлын ёсзүй, Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил, Хүүхэд хамгаалал Нийгмийн ажлын онол 1, 2
6	Г.Надмидцэрэн	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Багш	7 жил	Монголын түүх, соёл, ёс заншил Улс төр судлал
7	Б.Энх-Өлзий	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Багш	13 жил	Социологи Ёс зүйн үндэс Монголын түүх, соёл, ёс заншил Хүний хөгжил, ёс зүй
8	О.Саранчулуун	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Багш	13 жил	Нийгмийн ажлын нөлөөлөл Нийгмийн ажлын практик 2 Эрүүл мэндийн зан үйл Хөнгөвчлөх зөвлөгөө өгөх аргагүй
9	А.Ган-Эрдэнэ	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Багш	5 жил	Монголынтүүх, соёл, ёсзаншил
10	Д.Авирмэд	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Багш	7 жил	Сэтгэлгээний түүх философи, Хүний хөгжил, ёс зүй Социологи Хүн судлал
11	Т.Жаргалсайхан	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Дадлагажигч багш	4 жил	Нийгмийн сэтгэл судлал, Сэтгэл судлал, /анагаахын суурь/ Сэтгэл судлал, Хүний хөгжил, ёсзүй /Анагаахын суурь/
12	Г.Золжаргалан	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Дадлагажигч багш	4 жил	Нийгмийн хөгжил, Нийгмийн бодлого, Нийгмийн ажлын удиртгал, Нийгмийн ажлын менежмент, Нийгмийн халамж, хамгаалал
13	Д.Мөнх-Учрал	Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	Дадлагажигч багш	3 жил	Эрүүл мэндийг дэмжих, ХБХАНА, Жендер судлал, Нийгмийн эрүүл мэндийн үндэс Нийгмийн судалгаа 1, 2

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Анги	Сонгогдсон байдал
1	Б.Халиун	ЭМНА I	Сүхбаатар аймаг Онгон сум
2	М.Азжаргал	ЭМНА I	Дархан Уул. Аймгийн төвөөс элссэн
3	Э.Бундхорол	ЭМНА I	Дундговь. Аймгийн төвөөс элссэн
4	Г.Ариунтунгалаг	ЭМНА I	УБ. Чингэлтэй дүүргээс элссэн
5	П.Дуламсүрэн	ЭМНА I	Хөвсгөл Цагуун Уул сум Оюутны III байранд амьдарч байгаа
6	Н.Солонго	ЭМНА II	Сэлэнгэ аймаг. Оюутны I байранд амьдарч байгаа
7	Э.Анударь	ЭМНА II	Дорноговь аймгаас элссэн
8	Б.Дашдүзээ	ЭМНА II	Завхан аймгаас элссэн
9	О.Хулан	ЭМНА II	УБ. Баянгол дүүргээс элссэн
10	Б.Энхсанаа	ЭМНА II	Булган аймаг. МУБИС-ийн юутны байранд амьдарч байгаа
11	О.Амарбаясгалан	ЭМНА III	УБ Баянзүрх дүүрэг
12	Б.Түвшинбаатар	ЭМНА III	УБ Баянзүрх дүүрэг
13	Н.Номин	ЭМНА III	УБ Сонгино Хайрхан дүүрэг
14	Д.Дулмаа	ЭМНА III	Завхан аймаг Баянтэс сум Оюутны I байранд амьдарч байгаа
15	Ч.Борбилмаа	ЭМНА III	Сүхбаатар аймаг Онгон сумаас элссэн
16	С.Хулан	ЭМНА IV	УБ Хан-Уул дүүрэг.
17	С.Дидар	ЭМНА IV	Баян-Өлгий аймаг Баяннуур сумаас элссэн
18	Н.Саранзул	ЭМНА IV	Улаабаатар хот. Баянзүрх дүүрэг
19	Ө.Наранзаяа	ЭМНА IV	Булган аймгийн Могод сумаас элссэн
20	Б.Ганцэцэг	ЭМНА IV	Говьсүмбэр аймаг Шивээговь сум. Оюутны I байр

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Н.Үүрцайх	Геронтологийн Үндэсний төв	Хүний нөөцийн албаны дарга
2	Ч.Аззаяа	ХСҮТ, Сэргээн засах тусламж үйлчилгээний тасаг	Тасгийн эрхлэгч
3	Б.Баярмаа	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМТҮХ орлогч дарга
4	Н.Нямсүрэн	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМТҮХ орлогч дарга
5	Б.Уламбаяр	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	Хамтын ажиллагааны менежер
6	Т.Урнаа	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМТҮХ орлогч дарга
7	М.Одгэрэл	Сонгино Хайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМТҮХ орлогч дарга
8	Д.Хоролсүрэн	БЗД. 1-р хорооны Хүн Төвт ӨЭМТ	ӨЭМТ-ийн дарга
9	Б.Анхтуяа	БЗД. 17-р хорооны Орхон Түшээ Мөрөн ӨЭМТ	ӨЭМТ-ийн дарга
10	Ц.Ариунхишиг	СБД. 6-р хорооны Сайн наран ӨЭМТ	ӨЭМТ-ийн дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Ш.Лхагвадорж	2007	Эрүүл Мэндийн Хөгжлийн төв	Мэргэжилтэн
2	У.Эрхэмбаяр	2009	Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний төв	Эрдэм шинжилгээний ажилтан
3	Ц.Мөнхнасан	2014	Монголын Үндэсний Их Сургууль	Багш
4	Б.Дуламрагчаа	2013	Зоонозын Өвчин Үндэсний төв	Статистикч
5	Ц.Долгорсүрэн	2013	Геронтологийн Үндэсний төв	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
6	Х.Саранчимэг	2010	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	ЭМДА-ны дарга
7	Б.Одцэцэг	2013	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	ДОХ, БЗДХ-ын кабинет ЭМНА
8	П.Даваажаргал	2014	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	Сургалтын менежер
9	Б.Мөнхбаяр	2010	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	ДОХ, БЗДХ-ын диспансер эрхлэгч
10	Б.Довдон	2015	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	Өрхийн менежер
11	М.Жаргалмаа	2017	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
12	Ч.Гүнчинхорлоо	2018	Хан Уул дүүргийн эрүүл мэндийн төв	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
13	Ж.Цэнд	2018	Сүхбаатар дүүрэг Манай эмч ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
14	Б.Тунгалагболор	2015	Сүхбаатар дүүрэг Энэр Ази ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
15	М.Энхманлай	2013	Хан-Уул дүүрэг Цэд До ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
16	М.Биндэръяа	2018	Баянзүрх дүүрэг Ачитсайхан ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
17	Ж.Жанаргүл	2012	Баянзүрх дүүрэг Өнөр-Энхмэнд ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
18	Б.Батчимэг	2009	Баянзүрх дүүрэг Ачлахуй ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
19	Б.Батжаргал	2015	Чингэлтэй дүүрэг Шижид Дүг ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
20	М.Нуржан	2011	Чингэлтэй дүүрэг Энэрэнгүй Сэтгэл ӨЭМТ	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/